

АУДИТЫН КОД: САГ-2018/20/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Я.Самбууням

Утас: 261885 Цахим хаяг: sambuunyamyа@audit.gov.mn

Ахлах аудитор Л.Хонгорзул

Утас: 260512 Цахим хаяг: khongorzull@audit.gov.mn

Аудитор Б.Ариунжаргал


Утас: 260512 Цахим хаяг: ariunjargalb@audit.gov.mn

Улаанбаатар хот



АГУУЛГА

1	АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН.....	2
2	АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ.....	16
3	АУДИТЫН ТАЙЛАН.....	18
3.1	Оршил.....	18
3.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	18
3.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	19
3.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	19
3.5	Дотоод аудит.....	20
3.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	21
3.7	Хөрөнгө оруулалтын талаар.....	22
3.8	Шилэн дансны мэдээлэл.....	22
3.9	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	23
3.10	АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДАЛ, ГАРГАСАН ШИЙДЭЛ....	23
3.10.1	Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийхэд илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	23
3.10.2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	24
3.10.3	"Дипломат 95 цогцолбор" орон сууцны хувьчлалын талаар.....	25
3.11	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	26
3.12	Завсрын аудитаар авч үзэх асуудлууд.....	26
3.13	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	26
3.14	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	27
3.15	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	27
3.16	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	27
3.17	Үр өгөөжийн тооцоолол.....	27
4	МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	28
4.1	Үндсэн хөрөнгийн талаар.....	29
4.2	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар.....	30
5	АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	31
5.1	АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН.....	31
5.2	АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН.....	32
5.3	АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	33
5.4	АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН.....	34
5.5	АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН.....	35
6	АУДИТЫН ЯВЦАД ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГС ААЛТ.....	38
6.1	Албан шаардлага.....	40
6.2	Акт.....	42





МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД
Д.ЦОГТБААТАР ТАНАА

2018.04.25 № 1040

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



070466

Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

3 АУДИТЫН ТАЙЛАН

3.1 Оршил

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэл, төсвийн гүйцэтгэлийн тайлагнал, үйл ажиллагаандаа холбогдох хууль, дүрэм журмыг мөрдөж ажиллах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

3.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.


Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /цаашид УСНББОУС гэх/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөс 2018 оны 04 дүгээр сарын 16-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж,



Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Л.Хонгорзул, аудитор Б.Ариунжаргал нар хариуцаж хэрэгжүүлэв.

Гадаад харилцааны сайд 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2018 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 14/2068 дугаар албан бичгээр Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

3.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Гадаад хэргийн яам “Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний хөгжилд таатай гадаад орчныг бүрдүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Хилийн чанадад байгаа иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах;
- Дэлхийн улс орнуудтай бодит харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх;
- Бүс нутаг дахь байр сууриа бэхжүүлэх;
- Эх орныхоо нэр хүндийг өргөж, улсаа дэлхий нийтэд таниулах;
- Дипломат алба, үйл ажиллагааг шинэчилэх зэрэг болно.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхдээ “Монгол Улсын гадаад харилцааг үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалд тодорхойлсон зарчим, чиглэлээр улс орны болон дэлхий дахины улс төр, эдийн засгийн шинэ нөхцөл байдалтай уялдуулан тууштай хэрэгжүүлж, үндэсний язгуур эрх ашиг, тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн бие даасан, нээлттэй, олон тулгуурт гадаад бодлогыг идэвхтэй явуулах, гадаад бодлогын залгамж чанар, нэгдмэл байдлыг эрхэмлэж, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, олон улсын хамтын нийгэмлэгт эзлэх байр суурийг бэхжүүлэх, гадаад эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг тууштай явуулах зорилтуудыг удирдлага болгоно” гэж үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.8-д “Засгийн газрын гишүүн холбогдох төрийн захиргааны төв байгууллагын болон түүнд хууль тогтоомжоор харъяалуулсан бусад байгууллагын төсвийн” гэж заасны дагуу Гадаад харилцааны сайд төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.


Засгийн газрын 2016 оны “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай” 3 дугаар тогтоолоор Гадаад харилцааны яамны аппаратын бүтэц, орон тооны хязгаарыг баталсны дагуу 2017 оны жилийн эцсийн байдлаар улс төрийн албан тушаалтан - 3, төрийн тусгай албан хаагч /дипломат ажилтан/-97, төрийн захиргааны албан хаагч-21, төрийн үйлчилгээний албан хаагч-14, гэрээт ажилтан 7, нийт 142 хүн ажиллаж байна.

Хилийн чанадад Монгол Улсын 42 Дипломат төлөөлөгчийн газар үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эдгээрт нийт 377 ажилтан (дипломат-238, техник ажилтан-139) ажиллаж байна.

Гадаад харилцааны яамны үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

3.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000-1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.



Аудитаар Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал, дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд нягтлан бодох бүртгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна Гадаад харилцааны сайдын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод аудитын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 3.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 9 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 24 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 3.10 дахь заалтад хураангуйлан тэмдэглэв.

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого системтэй танилцахад 2009 онд боловсруулж баталсан Нягтлан бодох бүртгэлийн баримт бичигт өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу “Үндсэн хөрөнгийн бүртгэл” хэсэгт өөрчлөлт оруулж, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар баталгаажуулсан байна.

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамж ашигласан байна.

Гадаад харилцааны яамны санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг бэлтгэсэн байна.

3.5 Дотоод аудит

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Гадаад харилцааны яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь 2017 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг хэрэгжүүлж, яамны болон Дипломат төлөөлөгчийн газруудын үйл ажиллагааг сайжруулах талаар зааварлах захидал, зөвлөмж боловсруулан хүргүүлж, биелэлтийг тооцож ажилласан боловч санхүүгийн тайлангийн аудитаар санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэл, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой алдаа, зөрчил давтан илэрч байгаа тул дотоод аудитын хяналтыг “дунд” гэж үзлээ.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

ажиллагаанд 990.0 сая төгрөгийг хандив, тусламжийн эх үүсвэрээр бүрдүүлж, зарцуулахаар батлагдсан боловч дээрх эх үүсвэрийг бүрдүүлээгүйтэй холбоотой байна.

Тайлант оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаас үзэхэд зочин хүлээн авах зардлыг батлагдсан төсвөөс 155.7 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулснаас томилолт, зочны зардал бүлгийн дүнгээр 69.7 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг орлого, зардлын ангилал тус бүрээр аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн дэлгэрэнгүйд тусгаж тайлангийн 5.5-д харуулав.

3.7 Хөрөнгө оруулалтын талаар

Гадаад харилцааны яамны “Ёслол хүндэтгэлийн өргөө”-ний барилга ашиглалтад орохтой холбогдуулан Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар хөрөнгө оруулалтын зардалд 700.0 сая төгрөг, 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар нэмж 818.2 сая төгрөг, нийт 1,518.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зардлын төсөв батлагдсан байна.

Хөрөнгө оруулалтаар батлагдсан 1,518.2 сая төгрөгийн санхүүжилтийн 46.1 хувь буюу 700.0 сая төгрөг нь “Ёслол хүндэтгэлийн өргөө”-г барьж дуусгах ажлын зардалд, 53.9 хувь буюу 818.2 сая төгрөг нь тавилга, тоног төхөөрөмж худалдан авах зориулалтаар зарцуулагдсан байна.

Гадаад харилцааны яам Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48.2-ийн дагуу өөрийн төсвийн хүрээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөө, тайланг Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын хавсралтаар баталсан маягт №1, 2-т заасан үзүүлэлтээр гаргаж Сангийн яаманд хүргүүлсэн байна.


3.8 Шилэн дансны мэдээлэл

Гадаад харилцааны сайд төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хангах зорилтын хүрээнд shilendans.gov.mn цахим хуудасны төсөв/гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, бусад гэсэн цонхнуудад дараах мэдээллийг байршуулж байх үүрэгтэй байна. Үүнд:

А. Төсөв/гүйцэтгэл цэсэнд:

1. Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр);
2. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр);
3. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр);
4. Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр);
5. Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр);
6. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр);
7. Санхүүгийн тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр);
8. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (Бүтэн жилээр);
9. Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр).

Дээрх мэдээллийг нийтэд ил тод мэдээлсэн талаар шалгаж үзэхэд илэрсэн зөрчлийн талаар тайлангийн 3.10.2 дахь хэсэгт тусгасан болно.



3.9 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 9 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 24 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3.10.2-д материаллаг бус хураангуйлан тэмдэглэв.

3.10 АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДАЛ, ГАРГАСАН ШИЙДЭЛ

3.10.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийхэд илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн шууд захирагч 2, төвлөрүүлэн захирагч 1, Төрийн өмчит үйлдвэрийн газар 1, Засгийн газрын тусгай сан 2, төсөл хөтөлбөр 1, нийт 7 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн бөгөөд эдгээрийн 71.4 хувь буюу 5 нь аудитад хамрагдаж, бүгд зөрчилгүй дүгнэлт авсан, Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан, Олон улсын хамтын ажиллагааны сангийн 2017 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газраас аудитын түүвэрт хамруулж үзлээ.


Аудитаар илэрсэн бүх асуудлыг Төсвийн ерөнхийлөн захирагч болон яамны удирдлага, дотоод аудитын нэгж авч үзэж, судлан шийдвэрлэх шаардлагатай бөгөөд төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах асуудлыг Төсвийн ерөнхийлөн захирагчийн анхааралд онцгойлон хандуулж байна. Үүнд:

- Тайлант онд гадаад оронд суугаа зарим Дипломат төлөөлөгчийн газрууд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрөлгүйгээр урсгал зардлын төсвөөс 86.8 сая төгрөгөөр машин, тоног төхөөрөмж, Лондон дахь Элчин сайдын яам 102.7 сая, Бээжин дэх Элчин сайдын яам 195.3 сая, Прага дахь Элчин сайдын яам 106.7 сая төгрөгөөр тус тус автомашин худалдан авч, төсвийг зориулалт бусаар зарцуулсан, Москва дахь Элчин сайдын яам нь байрны түрээсийн орлогоос 127.1 сая төгрөгөөр автомашин худалдан авсан зэрэг нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах”, 23 дугаар зүйлийн 23.5-д “улсын төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ”, 23.5.2-т “төрийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

- Дипломат төлөөлөгчийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд авлагыг өмнөх оноос 205.1 сая, өглөгийг 458.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, нийт 2,658.4 сая төгрөгийн авлага, 1,130.4 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг толилуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

- Оросын Холбооны Улсын Улан-Үдэ хотод суугаа Монгол Улсын Консулын газрын барилгыг 1994 онд анх ашиглалтад ороход Монголын төмөр замын хэрэг эрхлэх газрын дарга болон Гадаад хэргийн сайд /хуучин нэрээр/-ын хооронд тус барилгын 3 өрөөг үнэ төлбөргүй эзэмших гэрээг байгуулснаас хойш 23 жил болоход гэрээний хугацаа дууссан эсэх нь тодорхойгүй, түрээсийн төлбөр төлдөггүй байна.

- Гадаад харилцааны яамны зочин төлөөлөгч хүлээн авах зардлаас тус үйл ажиллагааг зохион байгуулахтай холбогдолгүй гадаад томилолт, шуудан холбоо ахмалд



баяр, архивын 90 жилийн ой, эмэгтэйчүүдийн баяр зэрэг арга хэмжээнд нийт 17.7 сая төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоолын "төсвийн хөрөнгөөр шууд болон шууд бус хэлбэрээр шинэ жил, баяр ёслолын аливаа арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

- Гадаад харилцааны яамны санхүүгийн тайлангийн дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй "Ёслол хүндэтгэлийн өргөө"-ний барилга угсралтын ажил дуусч, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагаас ашиглалтад оруулах комисс ажиллаж дүгнэлт гаргасан боловч ашиглалтын гэрчилгээ гараагүй байхад үйл ажиллагаа явуулж эхэлсэн нь Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3-т "Гэрчилгээ олгогдоогүй, дуусаагүй барилга байгууламжид үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

- Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалт "АСЕМ"-ыг зохион байгуулсан үйл ажиллагаатай холбогдуулан Бүгд Найрамдах Хятад Ард Улсын буцалтгүй тусламжаар ирсэн зочид буудал болон албан тасалгааны зориулалттай нийт 1,273.7 сая төгрөгийн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоолын дагуу "Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь худалдан борлуулж, орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхээс 2017 оны жилийн эцсийн байдлаар нийт 509.9 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.

Аудитын явцад илэрсэн алдааг төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагч нар хүлээн зөвшөөрсөн байна.

3.10.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан талаар:


- Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны урсгал зардлын батлагдсан төсөв нийт дүнгээр хэтрээгүй боловч гадаад зочин, томилолтын зардлыг 69.7 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 14 дүгээр зүйлийн 14.2.3-т Төсвийн ерөнхийлөн захирагч "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтуудыг зөрчсөн, өмнөх аудитын зөвлөмжийг биелүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасан төсөв захирагчийн хүлээх үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага хүргүүлэх.

- Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны А/225, А/314 дүгээр тушаалуудаар Гадаад харилцааны сайдын гадаадад томилолтоор ажиллах зочид буудлын өрөөний тусгай үйлчилгээнд 7.9 сая төгрөг олгосон, гадаад зочны зардлаас 2.5 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалттай нийцэхгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.



Шийдвэрлэсэн нь: Зориулалт бусаар зарцуулсан 2.5 сая төгрөгийг төсөвт төлүүлэхээр акт тогтоох. Үргүй зарцуулсан 7.9 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлэх.

Үндсэн хөрөнгийн талаар

Гадаад оронд суугаа 4 Дипломат төлөөлөгчийн газрын 2012-2015 онд худалдан авсан 634.8 сая төгрөгийн үнэ бүхий автомашинуудыг аудитын зөвлөмжийн дагуу үндсэн хөрөнгийн дансанд 2017 онд нөхөн орлогод авахдаа өмнөх жилүүдэд ашиглагдсан хугацааны 124.7 сая төгрөгийн элэгдлийг нөхөн тооцоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт-16 “Үндсэн Хөрөнгө” гэсэн стандартаар элэгдлийн хугацааг “Хөрөнгийн ашиглалтын хугацаа нь тухайн хугацааны дундуур уг хөрөнгийг ашигласан болон ашиглаагүй эсэхийг үл харгалзан ашиглах боломжтой бүх хугацааг багтаах ёстой” гэсэн тодорхойлолттой нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дутуу тооцсон 124.7 сая төгрөгийн элэгдлийн зардлыг нөхөж тооцох зөвлөмж хүргүүлэх.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар


Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан эсэхийг шалгаж үзэхэд:

- Гадаад харилцааны яам нь (shilendans.gov.mn) вэб хуудсанд шилэн дансны мэдээллийг байршуулж ирсэн боловч өмнөх оны төсвийн зарцуулалтын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийн урамшуулал, зарцуулалтын тайланг байршуулаагүй;
- Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар нь Шилэн дансны төсөв гүйцэтгэл цэсэнд 9 мэдээлэл байршуулахаас санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан гэсэн 2 мэдээллийг огт байршуулаагүй;
- Далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын олон улсын судалгааны төвийн үйл ажиллагааг эхлүүлэх төсөл нь Шилэн дансны төсөв гүйцэтгэл цэсэнд 9 мэдээлэл байршуулахаас дараа жилийн төсвийн төслийг байршуулаагүй, цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн мэдээг 1-11 дүгээр сард хугацаа хоцорч байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг бүрэн байршуулах, уг хуулийг мөрдөж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх.

3.10.3 "Дипломат 95 цогцолбор" орон сууцны хувьчлалын талаар

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 5,336.9 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий "Дипломат 95 цогцолбор" орон сууцыг Засгийн газрын 2016 оны 315 дугаар тогтоолоор Гадаад харилцааны яамны албан хаагчдад үнэ төлбөргүй хувьчилсан шийдвэр нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын 1999 оны 64 дүгээр тогтоолыг зөрчсөн байх тул шийдвэрээ дахин хянаж үзэх талаар Монгол Улсын Ерөнхий сайдад хүсэлт гарган, холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар Гадаад харилцааны сайдад албан шаардлага хүргүүлсэн.



Дээрх албан шаардлагын хэрэгжилтийг хянаж үзэхэд Гадаад харилцааны сайд нь Үндэсний аудитын газрын албан шаардлагыг хэрэгжүүлэх чиглэлээр ямар нэгэн арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Засгийн газрын 2016 оны 315 дугаар тогтоол, Орон сууц хувьчлах товчооны 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 10 дугаар тогтоолыг үндэслэн Гадаад харилцааны яамны байрны “Батламж” авсан 80 хүнд орон сууц өмчлөх эрхийн гэрчилгээ олгогдсон байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй тул хууль, хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэв.

3.11 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Зарим Дипломат төлөөлөгчийн газрын санхүүгийн тайланд бүртгэлтэй барилга байгууламжийн эзэмшлийг нотлох баримт бичиг байхгүй /Бүгд Найрамдах Энэтхэг Улсад Элчин сайдын яам анх нээгдэхэд 1961 онд ашиглалтад орсон 579.5 мянган ам.долларын балансын үнэтэй барилгыг орон нутгийн иргэнээс худалдаж авсан боловч одоо хүртэл үл хөдлөх хөрөнгө эзэмшигчийн гэрчилгээ нь Элчин сайдын яамны нэр дээр шилжээгүй, Кайр дахь Элчин сайдын яамны 1998 онд баригдсан 2,605.4 мянган ам.долларын балансын үнэтэй барилгыг батлагдсан зураг төсвөөс зөрүүтэй баригдсан гэсэн шалтгаанаар улсын комисс хүлээж аваагүй, одоог хүртэл үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг аваагүй, Бээжин дэх Элчин сайдын яамны 1,293.2 мянган ам.долларын балансын үнэтэй барилга, байгууламж нь эзэмшлийн бичиг баримтгүй/ байна.

3.12 Завсрын аудитаар авч үзэх асуудлууд

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцэтгэсэн горим сорил, аудитын зарим чиглэлд өгсөн эрсдэлийн үнэлгээ, аудит хийж буй цаг хугацааны хязгаарлагдмал байдал зэргээс үзэхэд дараах чиглэлээр 2018 оны завсрын аудитаар нарийвчилсан горим сорил төлөвлөж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:


- Гадаад томилолт, зочны зардлын төлөвлөлтийн үндэслэл, гүйцэтгэл;
- Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын төлөвлөлтийн үндэслэл, гүйцэтгэл.

3.13 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар системийн хэмжээнд нийт 21,389.6 сая төгрөгийн алдаа, зөрчил нэгтгэж, баталгаажуулав.

Үүнээс, Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон энэ хүрээнд түүвэрт хамрагдсан байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 204.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2.5 сая төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож, 77.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, дутуу тооцсон 124.7 сая төгрөгийн элэгдлийн зардлыг нөхөж тооцох зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлж, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэв.

Нэгтгэлд хамрагдсан харьяа 5 байгууллага, аж ахуйн нэгж, төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагчийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 21,184.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 11,926.3 сая төгрөгийн материаллаг алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 120.7 сая төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож, 1,197.8 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх 2 албан шаардлага, 7,940.1 сая төгрөгийн зөрчилд 24 зөвлөмж хүргүүлсэн байна.



3.14 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газраас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгснөөс 2-ыг биелүүлж, Төсвийн тухай хуулийг мөрдөж, батлагдсан төсвийг хэтрүүлэхгүй ажиллах талаар өгсөн 1 зөвлөмж хэрэгжээгүй, зөрчил давтагдсан байна.

Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг Гадаад харилцааны яамны 2017 оны 14/6771 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн бөгөөд 2017 оны жилийн эцсийн байдлаар биелэлт 66.7 хувьтай байна. Дэлгэрэнгүй мэдээллийг ажлын баримтад хавсаргасан болно.

3.15 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг материаллаг байдлын түвшинг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 102,414.6 сая төгрөг, түүний 2 хувь 2,048.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тогтоосон бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд тооцсон суурь болон түвшинд өөрчлөлт ороогүй болно.

3.16 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 2.13-т тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 2 дугаар хэсэгт үзүүлэв.

3.17 Үр өгөөжийн тооцоолол

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт нийт 2,061.8 сая төгрөгийн үр өгөөжийн тооцооллыг хийж, Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн удирдлагаар баталгаажуулсан болно.



4 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт, аудитын дээд байгууллагын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, түүний дагуух бүртгэлийг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнууд болон Дотоод аудитын албаны холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



4.1 Үндсэн хөрөнгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт:

• Гадаад оронд суугаа 4 Дипломат төлөөлөгчийн газрын 2012-2015 онд худалдан авсан 634.8 сая төгрөгийн үнэ бүхий автомашинуудыг Дипломат төлөөлөгчийн газруудад хийсэн аудитын зөвлөмжийн дагуу үндсэн хөрөнгийн дансанд 2017 онд нөхөн орлогод авахдаа өмнөх жилүүдэд ашиглагдсан хугацааны 124.7 сая төгрөгийн элэгдлийг нөхөн тооцоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт-16 “Үндсэн Хөрөнгө” гэсэн стандартаар элэгдлийн хугацааг “Хөрөнгийн ашиглалтын хугацаа нь тухайн хугацааны дундуур уг хөрөнгийг ашигласан болон ашиглаагүй эсэхийг үл харгалзан ашиглах боломжтой бүх хугацааг багтаах ёстой” гэсэн тодорхойлолттой нийцэхгүй байна.

Эрсдэлүүд:

Дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

Үнэн зөв байдал - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх

ҮАГ-ын зөвлөмж:

Тайлант онд нөхөж орлогоор бүртгэсэн автомашинуудын ашигласан хугацааны 124.7 сая төгрөгийн элэгдлийн зардлыг нөхөж тооцох.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт албан ёсоор ирүүлэх

Төсвийн захирагчийн хариу:

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг Төсвийн ерөнхийлөн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан эсэхийг шалгаж үзэхэд:

-Гадаад харилцааны яам нь (shilendans.gov.mn) вэб хуудсанд шилэн дансны мэдээллийг байршуулж ирсэн боловч өмнөх оны төсвийн зарцуулалтын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийн урамшуулал, зарцуулалтын тайланг байршуулаагүй;

- Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар нь Шилэн дансны төсөв гүйцэтгэл цэсэнд 9 мэдээлэл байршуулахаас санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан гэсэн 2 мэдээллийг байршуулаагүй;

- Далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын олон улсын судалгааны төвийн үйл ажиллагааг эхлүүлэх төсөл нь Шилэн дансны төсөв гүйцэтгэл цэсэнд 9 мэдээлэл байршуулахаас дараа жилийн төсвийн төслийг байршуулаагүй, цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн мэдээг 1-11 дүгээр сард хугацаа хоцорч байршуулсан.

Энэ нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараахь мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Эрсдэлүүд

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байх

ҮАГ-ын зөвлөмж

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг бүрэн байршуулах, тус хуулийг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт албан ёсоор ирүүлэх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг Төсвийн ерөнхийлөн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.



5 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

5.1 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	17,024,510.17	14,962,658.23
31	Мөнгөн хөрөнгө	10,312,384.58	8,348,896.78
33	Авлага	3,959,811.50	4,130,470.41
34	Урьдчилгаа	97,335.48	78,907.55
35	Бараа материал	2,654,978.60	2,404,383.49
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	103,709,707.22	101,552,998.68
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	103,709,707.22	101,552,998.68
391	Газар	231,197.83	231,197.83
392	Биет хөрөнгө	103,269,351.89	101,108,563.47
393	Биет бус хөрөнгө	209,157.50	213,237.39
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	120,734,217.39	116,515,656.91
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,201,134.40	1,295,980.83
41	Богино хугацаат өр төлбөр	1,201,134.40	1,295,980.83
413	Өглөг	1,201,134.40	1,295,980.83
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	119,533,082.99	115,219,676.08
51	Засгийн газрын хувь оролцоо	119,533,082.99	115,219,676.08
512	Хуримтлагдсан үр дүн	(16,911,420.61)	(21,278,113.79)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,086,224.69	5,086,224.69
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	15,853,112.32	16,109,185.78
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	120,734,217.39	116,515,656.91



5.2 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	100,049,743.96	97,734,744.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24,905,689.59	32,789,865.86
120	Нийтлэг татварын бус орлого	24,864,789.91	32,707,350.97
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	75,144,054.37	64,944,878.74
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	106,401,137.56	102,412,540.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	106,401,137.56	102,412,540.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	83,447,989.32	69,212,814.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	24,542,623.31	26,775,164.38
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,006,290.79	970,267.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,843,467.78	12,774,430.43
2104	Хангамж, бараа материалын зардал	2,402,613.23	2,290,581.93
2105	Нормативт зардал	8,778.82	8,479.09
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,667,125.47	1,856,526.09
2107	Томилолт, зочны зардал	3,863,597.06	5,223,723.99
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,641,949.11	10,521,256.31
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,471,543.76	8,792,384.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,953,148.24	33,199,726.30
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(6,351,393.60)	(4,679,831.74)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	535,451.98	298,537.05
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	340,672.24	104,278.91
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	194,779.74	194,258.14
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(6,156,613.86)	(4,485,573.61)

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

5.3 АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/


Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	115,503,133.96	5,086,633.19	118,279.51	120,708,046.66
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	117.70	117.70
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	115,503,133.96	5,086,633.19	118,397.21	120,708,164.36
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	(408.50)	0.00	(408.50)
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	2,032.63	0.00	0.00	2,032.63
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	4,979,908.36	4,979,908.36
7	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(6,156,613.86)	(6,156,613.86)
8	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	115,505,166.59	5,086,224.69	(1,058,308.29)	119,533,082.99
9	2017 оны 1-р сарын 01-нээрх үлдэгдэл	115,505,166.59	5,086,224.69	(1,058,308.29)	119,533,082.99
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	118,880.43	118,880.43
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	115,505,166.59	5,086,224.69	(939,427.86)	119,651,963.42
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	(202,787.19)	0.00	0.00	(202,787.19)
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	256,073.46	256,073.46
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
16	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(4,485,573.61)	(4,485,573.61)
17	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	115,302,379.40	5,086,224.69	(5,168,928.01)	115,219,676.08



5.4 АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /мян.төг/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	101,473,225.95	98,409,443.61
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25,687,214.95	31,524,282.54
120	Нийтлэг татварын бус орлого	25,646,315.27	31,441,767.65
122	Хандив тусламж /гадаад/	40,704.69	82,514.89
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	75,786,011.00	66,885,161.06
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	99,775,491.81	96,364,561.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	99,775,491.81	96,364,561.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	76,133,126.43	62,414,432.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	25,271,974.05	27,357,418.63
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,171,382.29	1,254,910.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,688,260.48	14,180,867.82
2104	Хангамж, бараа материалын зардал	3,266,839.66	2,895,939.21
2105	Нормативт зардал	11,778.68	11,482.09
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	841,433.91	521,749.09
2107	Томилолт, зочны зардал	3,866,264.14	5,140,671.86
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,797,778.84	8,644,291.44
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,217,414.39	2,407,101.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,642,365.38	33,950,128.07
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,697,734.14	2,044,882.59
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(452,909.84)	(4,003,499.60)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	206,504.02	(4,870.79)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,451,328.32	(1,963,487.80)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,861,056.26	10,312,384.58
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,312,384.58	8,348,896.78



5.5 АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	65,383,765.20	61,555,413.49	(3,828,351.71)	94.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	63,865,565.20	60,037,213.49	(3,828,351.71)	94.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	59,776,509.80	55,969,385.37	(3,807,124.43)	93.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	25,597,073.80	24,578,687.34	(1,018,386.46)	96.0
210101	Үндсэн цалин	24,845,590.00	23,827,203.54	(1,018,386.46)	95.9
210102	Нэмэгдэл	629,592.00	629,592.00	-	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	121,891.80	121,891.80	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,043,113.20	922,566.25	(120,546.95)	88.4
210201	Тэтгэврийн даатгал	965,002.10	844,455.15	(120,546.95)	87.5
210202	Тэтгэмжийн даатгал	19,527.80	19,527.80	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,622.30	15,740.34	118.04	100.8
210204	Ажилгүйдлийн даатгал	3,905.50	3,906.30	0.80	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	39,055.50	38,936.66	(118.84)	99.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,418,926.70	12,273,651.31	(145,275.39)	98.8
210301	Гэрэл, цахилгаан	964,011.10	853,555.46	(110,455.64)	88.5
210302	Түлш, халаалт	1,270,593.80	1,244,572.64	(26,021.16)	98.0
210303	Цэвэр, бохир ус	443,666.90	440,407.45	(3,259.45)	99.3
210304	Байрны түрээс	9,740,654.90	9,735,115.76	(5,539.14)	99.9
2104	Хангамж, бараа материалын зардал	2,708,389.30	2,690,348.30	(18,041.00)	99.3
210401	Бичиг хэрэг	278,970.30	274,118.69	(4,851.61)	98.3
210402	Тээвэр, шатахуун	1,032,690.70	1,032,531.03	(159.67)	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	937,743.20	937,512.85	(230.35)	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	458,985.10	446,185.73	(12,799.37)	97.2
2105	Нормативт зардал	25,653.90	11,482.09	(14,171.81)	44.8
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	25,653.90	11,482.09	(14,171.81)	44.8

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН
ЗӨРНИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	731,893.70	731,484.00	(409.70)	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	207,083.00	206,693.84	(389.16)	99.8
210604	Урсгал засвар	524,810.70	524,790.17	(20.53)	100.0
2107	Томиллолт, зочны зардал	5,006,123.50	5,075,818.19	69,694.69	101.4
210701	Гадаад албан томиллолт	4,115,388.30	4,030,794.93	(84,593.37)	97.9
210702	Дотоод албан томиллолт	3,627.00	2,172.20	(1,454.80)	59.9
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	887,108.20	1,042,851.06	155,742.86	117.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,029,430.40	7,576,287.98	(1,453,142.42)	83.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,151,355.70	1,701,170.20	(450,185.50)	79.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,089.00	1,000.00	(89.00)	91.8
210803	Даатгалын үйлчилгээ	5,660,327.90	5,653,684.90	(6,643.00)	99.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	99.00	99.00	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19.80	19.80	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	990,000.00	-	(990,000.00)	-
210807	Газрын төлбөр	41,035.60	34,874.70	(6,160.90)	85.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	185,503.40	185,439.39	(64.01)	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,215,905.30	2,109,059.92	(1,106,845.38)	65.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,200,380.70	1,094,397.59	(1,105,983.11)	49.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,015,524.60	1,014,662.33	(862.27)	99.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,089,055.40	4,067,828.12	(21,227.28)	99.5
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	3,223,725.80	3,211,849.19	(11,876.61)	99.6
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	224,000.00	223,143.60	(856.40)	99.6



Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	449,629.60	441,435.33	(8,194.27)	98.2
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	191,700.00	191,400.00	(300.00)	99.8
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,518,200.00	1,518,200.00	-	100.0
	Барилга байгууламж	700,000.00	700,000.00	-	100.0
	Тоног төхөөрөмж	818,200.00	818,200.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	65,383,765.20	62,358,731.18	(3,025,034.02)	95.4
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	63,056,701.70	60,654,324.55	(2,402,377.15)	96.2
131001	Улсын төсвөөс санхүүжих	63,056,701.70	60,654,324.55	(2,402,377.15)	96.2
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,550,000.00	1,621,891.74	71,891.74	104.6
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	777,063.50	82,514.89	(694,548.61)	10.6
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	8,204,035.09		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	6,503,126.86		

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**